



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 25/163

Улаанбаатар хот

□ Удирдах зөвлөл болон Төлөөлөн □
удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж,
томилох тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 35 дугаар зүйлийн 35.1.11, 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 75 дугаар зүйлийн 75.4 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан “Удирдах зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1 дэх заалт, “Нийслэлийн Өмчийн оролцоотой хувь нийлүүлсэн хуулийн этгээдийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнээс хавсралтад дурдсан нэр бүхий гишүүдийг чөлөөлж, томилсугай.

2. Үйл ажиллагаагаа явуулахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллахыг томилогдсон гишүүдэд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн хороо (Б.Сэмжидмаа)-нд даалгасугай.

ДАРГА



А.БАЯР

1725020247



ХОТ ТОХИЖИЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР

Хөвсгөл лэйк сити товер-8/1, Багатойруу 1,
8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот, 14200
Утас/Факс: (976-11) 32 02 48
Цахим хуудас: www.umch.ub.gov.mn

2026.02.25 № 1/369
танай _____-ны № _____-т

Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах
тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/163 дугаар тогтоолоор танай үйлдвэрийн газрын удирдах зөвлөлөөс Л.Хосбаяр (Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч)-ыг чөлөөлж, С.Даваасүрэн (Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгч) томилогдсон.

Иймд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "Удирдах зөвлөлийн ажиллах журам" болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/163 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлан мэдээг улирал тутам тус газарт ирүүлэхийг мэдэгдэж байна.



Нийслэлийн өмчийн харилцааны газар
Захиргаа
Дарга
Володя Оюумаа
2026.02.25 16:09